




**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН
ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад “төсөв” гэж төрийн болон орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор төрийн мэдэлд хуримтлуулан хуваарилж, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр, төлбөр, санхүүгийн амлалт болон үүрэг, тэдгээртэй холбогдсон санхүүгийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүнгийн нийлбэр цогц гэж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтад "дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл" гэж тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг гэж, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд зөвхөн орон нутгийн төсвийн урьд оны ашиглаагүй үлдэгдлийг зарцуулах эрхийг нээх байдлаар төсвийн нийт зардал болон төсвийн алдагдлын дүнг 1 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгаж, бусад эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг өөрчлөхгүй байдлаар тооцсон болно.

Мөн төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөлд төсвийн хүрээний мэдэгдлийн үндсэн үзүүлэлтэд 2024 оноос өмнө мөрдөгдөж байсан “нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ”, “нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ” гэсэн хоёр үзүүлэлтийг нэмж тусгахаар боловсруулсан. Ингэснээр төсвийн зарлага, хөрөнгийн зардлын дунд хугацааны төлөвлөлтөд тавих хязгаарлалтыг тодорхой болгож, төсвийн сахилга батыг бэхжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь төсвийн тусгай шаардлагыг өөрчлөн найруулж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл болон нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтөд хязгаар тогтоох зохицуулалтыг тусгасан. Үүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2 хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байх, нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт болон өмнөх дараалсан 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджаас аль ихээс хэтрэхгүй байх зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Энэхүү зохицуулалт нь эрдэс баялгийн салбарын орлого, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс шалтгаалсан төсвийн зарлагын огцом өсөлтийг хязгаарлаж, төсвийн зарлагын өсөлтийг эдийн засгийн суурь, тогтвортой өсөлттэй уялдуулах ач холбогдолтой.

Дээрх нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлага, төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлахтай холбогдсон зохицуулалтыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн үндсэн үзүүлэлтүүдийг макро эдийн засгийн шинэчилсэн төсөөлөл, гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн тогтооход оршино.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн суурь үзүүлэлтүүдийг бодитой тооцож, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан улсын төсвийг оновчтой төлөвлөх, хуваарилах, төсвийн хөрөнгийг тэргүүлэх ач холбогдол бүхий арга хэмжээнд үр ашигтай зарцуулах нөхцөл бүрдэнэ.

Төсвийн тусгай шаардлагыг шинэчилсэн зохицуулалтад нийцүүлэн төсвийн үндсэн үзүүлэлтийг шинэчлэн тооцож, дунд хугацааны төсвийн хүрээг бодит эдийн засгийн нөхцөл болон төсвийн бодлогын зорилттой уялдуулах боломж бүрдэнэ.

Төсвийн бодлогыг эдийн засгийн өөрчлөлтөд нийцүүлэн цаг алдалгүй хэрэгжүүлэх боломж нэмэгдэж, инфляцын дарамт болон хүнс, эрчим хүч, шатахууны үнийн өсөлтөөс иргэдийн орлого, амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн төсвийн арга хэмжээг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ. Ингэснээр эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр нөлөөг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---